

Бизнесийн орчны бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Сүхээ Баатархүү

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт			
1	2	3	4	5		6	7	
3.1. Аж үйлдвэрийн төлөвлөлтийн бодлогыг орон зайн судалгаанд суурилан тодорхойлох, орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх								
1	Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг байршуулах виртуал серверийг үүсгэнэ	Үүсгэсэн виртуал серверийн тоо /1/	-	Мэдээллийн нэгдсэн сангийн виртуал серверийг ҮДТ дээр үүсгэсэн байна /1/	"2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Азийн хөгжлийн банктай хамтран Орон зайн мэдээллийн системийн Ажлын даалгавар боловсруулах Техник туслалцааны санамж бичиг MOU зурсан. Эдийн засаг, хөгжлийн яам нь бодлогын шинэчлэл, их өгөгдөл дээр суурилсан бодлого төлөвлөлтийг нэвтрүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банктай хамтран техник туслалцааны төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон. АХБ-аас 2025 оны 10-р сард техник туслалцааны төслийн баг Монгол Улсад ажилласан бөгөөд орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан нэвтрүүлэх асуудал хариуцсан газар болох БОБГ-ын дарга Л.Балчинлуvsантай уулзсан. Уулзалтаар АХБ-ны удирдлагаас санхүүжилтийн 80% бодлогын дэмжлэг, 20% систем нэвтрүүлэх бэлтгэл ажил болон холбогдох тооцоо, судалгааг гүйцэтгэхэд зориулах чиглэл өгсөн талаар мэдэгдсэн. Иймд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохиролцсон: Салбарын шинэчлэл, эдийн засгийн төрөлжилт, хувийн хэвшлийг дэмжих бодлогын дэмжлэг үзүүлэх; Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн		1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р	100%

					мэдээллийн нэгдсэн сангийн урьдчилсан судалгаа, техникийн даалгаврыг боловсруулах. Техник туслалцааны төслийн хүрээнд нийт 17 үндэсний зөвлөх, 1 олон улсын зөвлөхийг ажиллуулахаар төлөвлөөд байна. Нийгэм эдийн засаг болон байгаль орчны тухайлсан асуудлуудыг шийдвэрлэх тооцооллын загваруудыг ашиглан хөгжүүлэлт хийх- Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сантай холбоотой хөгжүүлэлтийг эхлүүлснээр тооцооллын загварыг ашиглан хөгжүүлэлт хийнэ.	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
2	Аж үйлдвэрийн төлөвлөлт, орон зайн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлын хүрээнд Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтран техник туслалцааны төсөл хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар /100/	2 талаас техник туслалцааны зорилго, хамрах хүрээ, үйл ажиллагаа, төсөв, хэрэгжилтийн зохион байгуулалтыг тохиролцсон. АХБ төслийг дэмжихээ илэрхийлж, эх үүсвэрийг баталгаажуулсан. Хувь	Техник туслалцааны тайланг эцэслэж, удирдлагын түвшинд баталж, санамж бичиг (MOU) зурна. /100 хувь/.	"2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Азийн хөгжлийн банктай хамтран Орон зайн мэдээллийн системийн Ажлын даалгавар боловсруулах Техник туслалцааны санамж бичиг MOU зурсан. Эдийн засаг, хөгжлийн яам нь бодлогын шинэчлэл, их өгөгдөл дээр суурилсан бодлого төлөвлөлтийг нэвтрүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банктай хамтран техник туслалцааны төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон. АХБ-аас 2025 оны 10-р сард техник туслалцааны төслийн баг Монгол Улсад ажилласан бөгөөд орон зайн төлөвлөлтийн мэдээчийн нэгдсэн сан нэвтрүүлэх асуудал хариуцсан газар болох БОБГ-ын даргатай уулзсан. Уулзалтаар АХБ-ны удирдлагаас санхүүжилтийн 80% бодлогын дэмжлэг, 20% систем нэвтрүүлэх бэлтгэл ажил болон холбогдох тооцоо, судалгааг гүйцэтгэхэд зориулах чиглэл өгсөн талаар мэдэгдсэн. Иймд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохиролцсон: Салбарын шинэчлэл, эдийн засгийн төрөлжилт, хувийн хэвшлийг дэмжих бодлогын дэмжлэг үзүүлэх; Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн урьдчилсан судалгаа, техникийн даалгаврыг боловсруулах. Техник туслалцааны төслийн хүрээнд нийт 17 үндэсний зөвлөх, 1 олон улсын зөвлөхийг ажиллуулахаар төлөвлөөд байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3.2. Эдийн засгийн салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийж, салбаруудын шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, либералчлалын бодлогыг тодорхойлж, холбогдох байгууллагууд, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдтэй хамтатган үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;							
3	"Нийгмийн	Мэдээлэл	-	Стандартыг	"Газрын албан хаагчдад ISO 26000 стандартын мөн чанар,	1-р	100%

	хариуцлагын ISO 26000" стандартыг нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилга агаар хангана.	сурталчилгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн тооны өсөлт, хувиар		нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилга агаар хангасан байна. /100 хувь/	зорилгыг ойлгож, энэ нь зөвлөмжийн шинжтэй, баталгаажуулалт хийдэггүй стандарт болох болон байгууллагын тогтвортой хөгжил, хууль дээдлэх зарчимд тулгуурладаг талаар мэдээллээр хангасан. Мөн нийгмийн хариуцлагын үндсэн ойлголт, байгууллагын шийдвэр үйл ажиллагааны нөлөө нийгэм, байгаль орчинд хэрхэн нөлөөлдөг тухай суурь мэдлэг, сонирхогч талуудын хүлээлт болон олон улсын хэм хэмжээг мөрдөх шаардлагын талаар мэдээлэл авсан. ISO 26000 стандартын долоон үндсэн бүрэлдэхүүн, хэрэглэгчтэй холбоотой шударга маркетинг, хэрэглэгчийн аюулгүй байдал, гомдол шийдвэрлэлт, хувийн нууц хамгаалалт зэрэг асуудлуудыг танилцуулсан. Стандартыг хэрэгжүүлэх үе шат болох оролцогч талуудыг тодорхойлох, үйл ажиллагаа-стандартын хоорондын зөрүүг илрүүлэх, зорилго зорилт тодорхойлох болон байгууллагын бүх түвшинд хэрэгжүүлэх арга замыг сурталчилсан. Мөн стандартыг хэрэгжүүлснээр нэр хүнд өсөх, өрсөлдөх чадвар нэмэгдэх, ажилтнуудын бүтээлч байдал сайжрах, сонирхогч талуудтай харилцаа сайжрах, хөрөнгө оруулалт татах боломж нэмэгдэх зэрэг ашиг тусыг танилцуулсан. ISO 26000 нь албадлагагүй, шаардлага агуулаагүй, гэрчилгээ олгодоггүй бөгөөд норматив стандарт биш гэдгийг албан хаагчдад ойлгуулсан. Түүнчлэн ISO 37301, ISO/TS 26030, ISO 9001, ISO 45001, ISO 14001 зэрэг уялдаа бүхий бусад стандартуудын талаар мэдээлэл өгч танилцуулсан. Хавсралт: 1 файл	сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
4	Бизнес эрхлэх орчны үнэлгээ хийх, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр дүн	Танилцуулгын тоо	Суурь судалгаа хийгдсэн -	Арга хэмжээний танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/	"ЭЗХЯ-аас бизнесийн орчны үнэлгээг судалж Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулснаар бизнес эхлүүлэхэд гардаг хүндрэл, шат дамжлагыг бууруулах, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах чиглэлээр 7 дугаар тэмдэглэл гарсан. Энэ хүрээнд: Хуулийн этгээд байгуулах шат дамжлагыг цөөлж, цахимжуулах, ажлын 3 өдөрт багтаан ашгийн төлөө хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэх; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх бизнесийн төрлийг цөөлж оновчтой тогтоох; Цахилгаан эрчим хүчинд холбогдох зөвшөөрөл олгох, холболт хийх хугацааг 40 хоногт багтаах;	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

FE

	шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.				Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, үйл ажиллагааг www.license.mn-д нэгтгэх, цахимаар шийдвэр гаргах хугацааг тогтоох, төрийг үйлчилгээний нэгдсэн системд холбох зэрэг үүрэг, даалгавар өгөгдөж, хэрэгжилтийг үе шаттай ханган ажиллаж байна.	сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
5	Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг шинэчлэн боловсруул ахад дэмжлэг үзүүлж ажиллана.	Журмын тоо	-	Журмыг батлуулсан байна. /1 баримт бичиг/	"Ерөнхий сайдын 41 дүгээр захирамжаар байгуулагдсан Экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсгийн хүрээнд "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэх үүрэг өгсөн. Холбогдох байгууллагуудын төлөөллийг тодорхой чиглэлээр нь оруулан журам шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан. "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын төсөлд олон нийтээс санал авах асуулгыг 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 11-ний өдрийн хооронд ГЕГ, "СМТТ" УТҮГ, МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулж ажилласан. Цахим санал асуулгад нийт 18314 оролцогч оролцсон. Нийт оролцогчдын 30 гаруй хувь нь гаалийн үйл ажиллагаатай холбоотой саналыг ирүүлсэн. Нээлттэй хэлэлцүүлгийг МҮХАҮТ-ын Их танхимд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Гаалийн ерөнхий газар болон МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгээр иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллүүд импортын хяналт, бүрдүүлэлттэй холбоотой саналыг тусгайлан өгсөн бөгөөд журамд тусгасан. Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/337 дугаартай тушаалаар "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан журмыг ХЗДХЯ-нд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд 2025 оны 09 дүгээр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

сарын 01-ний өдөр бүртгүүлсэн.

3.3. Хувийн хэвшлийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад төрийн оролцоог багасгах үндсэн чиглэлийн бодлого боловсруулах, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход чиглэсэн арга хэмжээг тодорхойлох, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;

6	Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Бизнес эрхлэгчдээс ирүүлсэн гомдол шийдвэрлэлтийн явц, хувиар	-	Бизнесийн орчин, төрийн хүнд сурталтай холбоотой гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэсэн байна. /100/	" Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоол, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын шийдвэрийн хүрээнд, төрийн үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах зорилгоор "e-Business" нэгдсэн системийг ашиглан байгууллагын бүртгэлийн дугаар олгох, хүчингүй болгох үйл ажиллагааг олгоно гэж заасан. Энэ шийдвэрийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн байгууллагын бүртгэлийн дугаар, тамга, тэмдгийн хяналтын дугаарыг "e-Business" цахим системээр дамжуулан олгож эхэлсэн. Байгууллагууд хуульд заасан бүртгэл, хяналтын дугаар авах, дахин олгох болон холбогдох үйлчилгээний хүсэлтийг "e-Business" системээр илгээж, цахимаар хүлээн авах боломжтой болсон. Салбар хоорондын уялдааг сайжруулах, шийдвэрлэх: Бизнес эрхлэгчдээс МҮХАҮТ болон УБХХТ-аар 103 санал ирүүлсний дагуу 9-н асуудлыг хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг холбогдох журмын зохицуулалтаар шийдвэрлэж, 22 асуудал буюу 21 орчим хувь нь хууль, эрх зүйн орчны шинэчлэл, өөрчлөлтөөр, 69 асуудал буюу 67 орчим хувь холбогдох дүрэм, журам, зохицуулалтаар шийдвэрлэх боломжтой байна. Үлдсэн асуудлууд буюу 12 орчим хувь нь бусад байдлаар буюу шинэ журмын зохицуулалт гаргах, салбар хоорондын уялдааг сайжруулах зэргээр шийдвэрлэх боломжтой асуудлыг ангилан боловсруулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
7	Бизнесийн орчинтой холбоотой гомдлыг хүлээн авч, хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлж	"11-11 төв"-ийн цахим системд хийсэн шинэчлэл	-	"11-11 төв"-ийн цахим системд бизнесийн орчинтой холбоотой гомдол хүлээн авах цонх	"Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв болон тус яаманд иргэдээс ирүүлж буй гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх. Мөн тус төвийн системд шинэчлэл хийх: ААН-с ирүүлсэн гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг болсон. Тус яаманд ирүүлсэн 43 гомдол саналаас 39-г шийдвэрлэж, 4 гомдол, хүсэлт хяналтын шатанд байна. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах "11-11.mn" төвийн системд бизнес эрхлэгчдээс ирүүлж буй гомдлыг ангилах шошго нэмж, бүлэглэж харах боломжтой болсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	100%

	шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ.			нэмсэн байна.	Бизнес эрхлэгчдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийг BIG data Dashboard бодит цагийн горимд байнга мэдээлэх боломжтой болсон. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах "11-11.mn" төвийн системд бизнес орчинтой холбоотой гомдлыг ангилах, тайлагнах хөгжүүлэлтийг хийсэн. Эдийн засаг, хөгжлийн яаманд албан бичгээр ирүүлсэн санал, гомдлыг Бизнесийн орчны бодлогын газар хүлээн авч холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Тус яаманд ирүүлсэн 43 гомдол саналаас 39-г шийдвэрлэж, 4 гомдол, хүсэлт хяналтын шатанд байна.	сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
8	Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын хүрээнд зохион байгуулна.	Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо /1/	-	Хувийн хэвшлийн оролцоог хангаж, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. /1/	"Монгол Улсын Засгийн газраас Баялаг бүтээгчдийг дэмжих багц хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү багц хуулийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас ""ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ"" анхдагч хуулийн төслийг дагах 100 гаруй хуулийн төслийн хамт боловсруулж олон нийтээс санал авахаар байршуулсан. Энэхүү ажлын хүрээнд 10 дугаар сарын 02-ны өдөр МҮХАҮТ хамтран хувийн хэвшил бизнес эрхлэгчдийн дунд хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийсэн. Уг хэлэлцүүлэгт төр, хувийн хэвшил, судлаачид, мэргэжлийн холбоод болон иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн нийт 150-200 оролцогч оролцож, хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулалтын онцлог, хэрэглээний боломж, эрсдэл, цаашдын сайжруулалтын талаар санал бодлоо солилцов. Хэлэлцүүлгийн явцад оролцогчид эдийн засгийн эрх чөлөөг бодитой хэмжих аргачлал, төрийн оролцоо болон макро бодлогын уялдаа, хүний капиталын асуудал, бизнесийн орчны хууль эрх зүйн тогтвортой байдал, боловсруулсан заалтуудын нарийвчлал, давхардал, ойлгомжтой байдлын талаар тодорхой саналуудыг дэвшүүлсэн. Оролцогчдын гаргасан саналуудыг нэгтгэн дүгнэж, хуулийн төслийн нарийвчлалыг нэмэгдүүлэх, хэмжигдэхүүнийг үндэслэлтэй тодорхойлох, бусад хууль тогтоомжтой давхардлыг арилгах, эдийн засгийн эрх чөлөөний үнэлгээний	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр сайжруулалт хийх шаардлагатай гэж үзэв. Хэлэлцүүлгийн үр дүнгийн нэгтгэл, санал дүгнэлтийг нэгтгэн боловсруулсан. Хавсралт: 1 файл	сар	
3.4. Жижиг, дунд болон гарааны бизнесийг дэмжих бодлого, тогтолцоог хөгжүүлж, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;							
9	Гарааны бизнесийг дэмжих тогтолцоог хөгжүүлэх, хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах санал зөвлөмж боловсруулсан байна.	Санал, Зөвлөмж боловсруулсан тоо	-	Санал, Зөвлөмж боловсруулсан байна. /1/	"Монгол улсын гарааны бизнесийг дэмжих, гарааны бизнес бойжуулагч инкубаторуудын үйл ажиллагааг өргөжүүлэх, технологийн шийдэл, инновацын бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд гарахад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Тэжан хотын Бүтээлч эдийн засаг, инновацын төвтэй харилцан туршлага, зөвлөмж солилцох ажлыг зохион байгуулж 2025 оны 09 дүгээр сарын 04-нд Шинжлэх Ухааны Академи болон БНСУ-ын Тэжан хотын Бүтээлч эдийн засаг, инновацын төвтэй "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг баталсан. Мөн, 09 дүгээр сарын 04-09-ны өдрүүдэд Улаанбаатар хотод БНСУ-ын гарааны бизнесүүдийн танилцуулга хийх өдөрлөгийг зохион байгуулж, дотоодын инкубатор байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх, гадаадын гарааны бизнес хөгжүүлэгч инкубатор байгууллага болон гарааны бизнесүүдтэй өргөн хүрээнд хамтран ажиллах боломжийг өргөжүүлэх ажлыг зохион байгуулав. Энэхүү ажлын хүрээнд Шинжлэх ухааны Паркийн захиргаа, Бүгд Найрамдах Солонгос Улсын Тэжан хотын Бүтээлч эдийн засаг, инновацын төвтэй хамтран "PITCH TO PARTNERSHIP: Unlocking Mongolia-Korea Market Entry" өдөрлөгийг БНСУ-ын Тэжан хотод 2025 оны 09 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулж Монголын 20 орчим гарааны бизнес, гарааны бизнес хөгжүүлэх инкубаторуудын хамт Солонгосын хөрөнгө оруулагч, хамтран ажиллах байгууллагуудад дотоодын шинэлэг санаа, технологийн шийдлийг танилцуулах, бий болгох, хамтран ажиллах боломжийг өргөжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулан ажиллаа. Дээрх өдөрлөгийн хүрээнд гарааны бизнес эрхлэгчдэд тулгамдаж байгаа асуудал болон төрөөс үзүүлж буй дэмжлэгийн хүртээмжийн талаарх оролцогчдын саналыг хурааж дараах чиглэлээр гарааны бизнесийг дэмжих эрх зүйн орчныг ажлыг зохион байгуулахаар судлан ажиллаж байна. 1. Гарааны бизнесүүдийг Нийгмийн даатгалын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					шимтгэлээс тодорхой хугацаанд хөнгөлөх эрх зүйн орчныг бий болгоход чиглэсэн. 2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан гарааны бизнес эрхлэгчдийг тодорхойлох ажлыг хөнгөвч		
3.5. Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс олгох зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх, төрийн бус байгууллагад шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;							
10	Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын нэгдсэн санд мэдээлэл оруулж байгаа байдалд дүн шинжилгээ хийх, цахим системд оруулаагүй нөхцөл шаардлагыг тодорхойлн о.	Хэрэгжилтийн явц, хувиар /100/	-	Зөвшөөрлийн нэгдсэн санд олгосон зөвшөөрлийн мэдээлэл оруулах нөхцөл, шаардлага бүрдсэн байна. /100 хувь/	"Зөвшөөрлийн тухай хуулиар ЭЗХЯ нь Зөвшөөрлийн нэгдсэн санг эрхлэн явуулдаг. Зөвшөөрлийн цахим системийг өнөөдрийн байдлаар 11 байгууллага бүрэн хэмжээнд буюу зөвшөөрлийн хүсэлт хүлээн авахаас олгох хүртэлх бүх үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба 34 байгууллага зөвхөн нь мэдээлэл оруулах эрх нээлгэсэн байна. Эдгээр 34 байгууллага мэдээлэл оруулах эрх авсан хэдий ч 122 төрлийн зөвшөөрөл дээр ямар нэг мэдээлэл оруулаагүй байна. Зөвшөөрлийн нэгдсэн санд 2025-09-15-ны өдрийн байдлаар Хуулийн этгээдийн 24,363, Иргэний 145,961 зөвшөөрлийн мэдээлэл бүртгэлтэй байсан бол 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар Хуулийн этгээдийн 32251, Иргэний 146520 зөвшөөрлийн мэдээлэл бүртгэлтэй байна. Зөвшөөрлийн тухай хуульд орсон тусгай болон энгийн нийт 371 зөвшөөрөл байгаагаас e-business.mn платформд холбосон 134 тусгай, 43 энгийн зөвшөөрлүүд байна. Харин энэхүү платформд огт холбогдоогүй 76 тусгай, 58 энгийн зөвшөөрлүүд байна. License.mn Зөвшөөрлийн нэгдсэн санд 231 бүртгэлтэй хэдий ч 50 зөвшөөрөл цахим хэлбэрт шилжээгүй, 121 энгийн зөвшөөрлөөс Зөвшөөрлийн нэгдсэн санд 90 бүртгэлтэй ч мэдээлэл оруулаагүй 43 зөвшөөрөл байна. Үүнтэй холбоотой эрх бүхий байгууллагуудад мэдэгдэж мэдээлэл оруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллав.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
11	Эрх бүхий байгууллага удад админ болон зөвшөөрлийн үе шат	Мэдээллийн тоо	-	Эрх бүхий байгууллага удад сургалт, мэдээлэл өгсөн	Зөвшөөрлийн цахим системийн админ хэрэглэгчдэд зориулсан нэвтрэлт, хэрэглэгч нэмэх, эрхийн тохиргоо, системийн шаардлага, шалгуур үзүүлэлт, хүсэлт шийдвэрлэх хоногийн тохиргоо болон нөхцөл шаардлага зэрэг сэдвээр 25 эрх бүхий байгууллагуудад 2025 оны 09 дүгээр сарын 18, 10 дугаар сарын 08 болон 31-ний өдрүүдэд сургалт зохион байгуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар,	100%

	бүрийн тохируулах эрхийн талаар сургалт, мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулна.			байна.	https://medgov-my.sharepoint.com/:f/g/personal/zolzaya_t_med_gov_mn/IgAR_Zgk5thxRrfStuFRvSR3AaGB-RLE7MxTQmktFTMYEgQ?e=ochJ5o Хавсралт: 1 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
1 2	Зөвшөөрлийн эрх шилжүүлэх журам, холбогдох хуулийн төсөл шинэчлэх бэлтгэл ажлыг хангана.	Хэрэгжилтийн явц, хувиар /100/	-	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	"Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд "хуульд заасан тохиолдолд" эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох эрхээ "бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн": 1/төрийн холбогдох байгууллага, 2/албан тушаалтан, эсхүл 3/холбоо /төрийн бус байгууллага/, 4/нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж болно мөн эрх шилжүүлэх журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу "Журам батлах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Журмын төслийг боловсруулахдаа хэрвээ эрх бүхий этгээд бусад төрийн байгууллага, албан тушаалтан, эсхүл нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох эрхээ шилжүүлж байгаа мөн бусад хуульд өөр процесс тогтоогоогүй бол эрх шилжүүлэх шийдвэрийг Засгийн газрын тогтоолоор шилжүүлэхээр заасан ба энэ тохиолдолд гэрээ байгуулах шаардлагагүй. Харин нөхцөл шаардлага хангасан мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад зөвшөөрөл олгох эрхээ шилжүүлэх бол эрх шилжүүлэх гэрээг байгуулна. Монгол улсын Засгийн газрын 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 106 дугаар тогтоолоор Зөвшөөрөл олгох эрх шилжүүлэх журмын төслийг батлуулав. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17433540909802"	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

						Хавсралт: 1 файл	11-р сар, 12-р сар	
--	--	--	--	--	--	------------------	-----------------------	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	“Зүүн Ази форум 2025 - Ази, Номхон далайн бүс нутгийн өндөр чанартай хөгжлийг ахиулах нь: Бүтээмж, инновац ба эдийн засгийн нээлттэй байдал” сэдэвт сургалтад хамрагдсан байна.	Форумд оролцох	-	1	“Зүүн Ази форум 2025 - Ази, Номхон далайн бүс нутгийн өндөр чанартай хөгжлийг ахиулах нь: Бүтээмж, инновац ба эдийн засгийн нээлттэй байдал” сэдэвт сургалтад хамрагдсан. Хавсралт: 9 файл	9-р сар	100%
2	Яамнаас зохион байгуулдаг мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх.	мэдээллийн цагт хамрагдсан байна.	-	тогтмол хамрагдсан байна. /100 хувь/	Бизнесийн орчны бодлогын газраас “Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах” талаар мэдээллийн цагт хамрагдсан Төрийн захиргааны удирдлагын газраас зохион байгуулсан “Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

59

				үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж" сэдвээр Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, Профессор Бадгарын Батцэцэг мэдээлэл өгсөн мэдээллийн цагт хамрагдсан. Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газраас 2025.10.27-нд зохион байгуулсан мэдээллийн цагт хамрагдсан. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулууны "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" мэдээлэлд хамрагдсан.	
--	--	--	--	--	--

ТАНИЛЦСАН:

Бизнесийн орчны бодлогын газрын дарга, Лхагвасүрэн Балчинлувсан /...../

Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Бизнесийн орчны бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Сүхээ Баатархүү /...../

Огноо:

2022.12.12

